

Сургалтын хөтөлбөрийн хорооны
2024 оны 09 дүгээр сарын 23 ний өдрийн
6 дугаар тогтоолын хавсралт



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИЙН
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРОО

СУРГАЛТЫН НЭГДСЭН БОДЛОГО (2025-2027 ОН)

**СУРГАЛТЫН НЭГДСЭН БОДЛОГО
(2025-2027ОН)**

ТОВЬЁГ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР.СУРГАЛТЫН УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ

- 2.1.Сургалтын хэрэгцээ, шаардлагын судалгаа
- 2.2.Сургалтын төлөвлөлт
- 2.3.Сургагч багш
- 2.4.Шүүгч-сургагч багш
- 2.5.Сургалтын хөтөлбөр
- 2.6.Сургалтын мэдээлэл
- 2.7.Сургалтын зардал

ГУРАВ.СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.1.Сургалтын төрөлжилт
- 3.2.Сургалтын хэлбэр, арга зүй

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

- 4.1.Оролцогчийн суралцахуйг үнэлэх
- 4.2.Сургалтын ажиллагааг үнэлэх

ТАВ.НЭГДСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

СУРГАЛТЫН НЭГДСЭН БОДЛОГО (2025-2027 ОН)

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан шүүгч бэлтгэх болон шүүгчийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг судалгаа, мэдээллээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи /цаашид “Шүүхийн академи” гэх/ Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.” гэж, 24.2 дахь хэсэгт “Шүүхийн академи сургалтын хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэг бүхий бүх шатны шүүхийн шүүгч, Ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус хороотой байна.” гэж, 24.3 дахь хэсэгт “Шүүхийн академийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийг Улсын дээд шүүхийн танхимын саналыг харгалзан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч батална.” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 2021-2030 онд хэрэгжүүлэх “5.1.Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана.” гэсэн зорилтын хүрээнд “3.Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинэ.” гэж, мөн Ухаалаг засаглалын чиглэлд “5.1.9.Шүүх үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно.”, “5.1.10.Ёс зүй, цогц чадамжтай шүүхийн хүний нөөц бэлтгэх суурь тогтолцоог бий болгож, төгөлдөржүүлнэ.” гэж тодорхойлсон.

Улсын Их Хурлын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-нд шүүх эрх мэдлийн суурь үнэлэхүйг “хараат бус байх”, “хариуцлага хүлээдэг байх”, “мэдрэмжтэй байх”, “шударга байх”, “хүртээмжтэй байх”, “бүтээмжтэй байх” гэсэн чадвараар тодорхойлж, мэдрэмжтэй байх суурь үнэлэхүйн хүрээнд шүүх эрх мэдэлд тавигдаж байгаа нийгмийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан харж, өөрчлөлт шинэчлэлтийг цаг тухайд нь хийх чадвартай байхыг тусгасан.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг үндэслэн Улсын дээд шүүхийн танхимын саналыг харгалзан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2024 оны 49 дүгээр захирамжаар баталсан “Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн ажиллах журам”-ын 4.5-т Шүүхийн сургалтын төв нь Сургалтын хөтөлбөр боловсруулах хороотой хамтран ажиллаж, тус хорооноос гаргасан сургалтын нэгдсэн бодлогын хүрээнд үйл ажиллагаа явуулна гэж заасан.

Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын 6.3-т “Шүүгч нь шүүгчийн мэдлэг, ур чадвар, хувийн чанарыг дээшлүүлэх, сайжруулах зохих арга хэмжээг тухай бүр авах бөгөөд энэ зорилгоор шүүгчийн албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай шүүхийн сургалт, бусад арга хэрэгслийг зохих ёсоор бүтээлчээр ашиглана.” гэж тусгасан.

“Европын шүүхийн сургалтын сүлжээ” байгууллага 2016 онд “Шүүхийн сургалтын зарчмууд”-ыг, мөн “Шүүхийн сургалтын олон улсын байгууллага” 2017 онд “Шүүхийн сургалтын зарчмуудын тунхаг”-ийг тус тус баталж, шүүхийн сургалтын сайн туршлагууд бий болсон. Шүүхийн сургалтын бодлого, стратегийг цаг хугацаа, үе шаттай батлан хэрэгжүүлж

байгаа практик Европын зөвлөлийн шүүхийн сургалт эрхэлсэн байгууллага болон гадаад улсуудад түгээмэл байна.

Шүүхийн сургалтын асуудлыг зохицуулсан хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг үндэслэн, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг харгалзан Сургалтын хөтөлбөрийн хороо энэхүү Сургалтын нэгдсэн бодлогыг 2024 оноос эхлэн гурван жилийн хугацаанд зохион байгуулах сургалтад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд энэхүү нэгдсэн бодлогын хэрэгжилтийн үнэлгээнд үндэслэн дараагийн шатны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Сургалтын 2025-2027 оны нэгдсэн бодлогын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Сургалтын үйл ажиллагаа, агуулга шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг ямагт сахих, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад чиглэнэ.
2. Сургалтын хэрэгцээ, шаардлагыг шүүх, шүүтч болон шүүхээр үйлчлүүлэгчдээс тандан судална.
3. Сургалтыг шүүгч-насанд хүрэгчийг сургах арга зүйд суралцсан сургагч багш хөтлөн явуулна. Сургалтыг шүүтч-сургагч багш хөтлөн явуулахыг хөхиүлэн дэмжинэ.
4. Сургалт эрх зүйн болон бусад салбарын мэдлэгийг хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн олон талт байдлыг мэдрэх хандлага чадварыг ахиулахад чиглэнэ.
5. Сургалтад шинэлэг, орчин үеийн дэвшилтэт хэлбэр, аргыг нэвтрүүлж, алсын зайн сургалтыг нийт зохион байгуулаж буй сургалтын 70 хувьд хүргэх бие даан ажлын байран дээр суралцах сургалтын арга зүйг нэмэгдүүлэхэд чиглэн оролцоот сургалтын хэлбэр, арга зүйг түгээмэл хэрэглэнэ. Оролцоот сургалтын арга зүйн 70:20:10 зарчим буюу сургалтын 70 хувьд хийнгээ-суралцах, 20 хувьд бусад оролцогчдоос суралцах, 10 хувьд лекц, контентоос суралцах арга зүйг нэвтрүүлэх зорилгын хүрээнд хийнгээ суралцах сургалтын эзлэх хувийг үе шаттай ахиулж сургалтын чанарыг хангана.
6. Сургалтын ажиллагааг цогцоор үнэлнэ. Сургалтын үнэлгээний шилдэг арга, хэлбэр, сайн туршлагыг харгалзан сургалтад оролцогчийн суралцахуй, сургагч багшийн ажил, сургалтын зохион байгуулалтыг бодитой үнэлэх арга хэмжээг хэрэгжүүлж, үнэлгээний тайланг цаашдын сургалтын ажиллагааг сайжруулахад харгалзаж, эргэлтэд оруулна.

Шүүхийн академи энд дурдсан зорилтыг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжид заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллага болон хөгжлийн хамтын ажиллагааны түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллана.

ХОЁР.СУРГАЛТЫН УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ

2.1.Сургалтын хэрэгцээ, шаардлагын судалгаа

Шүүхийн хэрэгцээ, шүүгчээс жил бүр авах тандан судалгаанд тулгуурлан шүүгч, шүүгч бэлтгэх сургалт зохион байгуулна.

Шүүгчийн сургалтын хөтөлбөр боловсруулахын өмнө сургалтын хэрэгцээ, шаардлага, зорилгыг дараах сурвалжаас тандан судална:

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалтын хэрэгжилтийг хангаж Шүүгчдийн зөвлөгөөн шүүгчийг мэргэшүүлэх сургалтын санал ирүүлэх боломж бүрдүүлэх;
2. Шүүгч бүрийн сургалтын хэрэгцээг шүүхийн чиг үүрэг, зохион байгуулалтын хэрэгцээ, шаардлагатай уялдуулан авч үзэх, төлөвлөж буй, эсхүл хамрагдах хэрэгцээ бүхий сургалтын талаар шүүгч саналаа өгөх байнгын ажиллагаатай цахим тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх;
3. Академийн Шүүхийн судалгааны төвөөс гүйцэтгэсэн хуулийг зөв хэрэглэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал уламжлахад шаардагдах судалгааны тайланд үндэслэн сургалтын хэрэгцээг тодорхойлох;
4. Шүүн таслах ажиллагааны статистикт үндэслэн сургалтын хэрэгцээг тодорхойлох;
5. Шүүгчийн эзэмшвэл зохих мэдлэг, ёс зүй, ур чадвар, тэдгээрийг хөгжүүлэх талаар шүүхээр үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээд, хуульчийн саналыг авах.

Шүүгч бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулахад шаардлагатай бол Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүгчийн ёс зүйн зөвлөх хорооноос санал авч болно.

2.2.Сургалтын төлөвлөлт

Дараа жилийн сургалтын сэдэв, цагийг өмнөх оны IV улиралд төлөвлөсөн байвал зохино. Сургалтыг хангалттай хугацааны өмнө урьдчилан төлөвлөх нь оролцогч ажиллангаа суралцах зохион байгуулалтыг хангах, шүүгч-багш, гэрээт багш (цаашид “сургагч багш” гэх) сургалтад сайн бэлтгэх нөхцөл бүрдүүлнэ.

Сургалтын тов, сургалт зохион байгуулах хэлбэрийг тогтооход оролцогчдын ажлын ачаалал, зам тээврийн хүчин зүйл, холбогдох бусад нөхцөл байдлыг харгалзаж цахим хэлбэрээр болон нийслэлд, эсхүл орон нутагт бүсчлэн танхимын хэлбэрээр зохион байгуулна.

Тодорхой сэдэвт төвлөрсөн сургалтыг шүүгч өөр шүүхийн шүүгчтэй харилцах, санал бодол, туршлагаа хуваалцах, солилцох боломж бүрдүүлж зохион байгуулна.

Сургалтад олон оролцогч хамрагдах тохиолдолд оролцогчдыг бүлэгт хуваан сургалтыг давтамжтай хийх, подкаст, вебинар, видео сургалт байршуулж сургалтын үр өгөөж, чанарыг хангана.

2.3.Сургагч багш

Сургагч багш сургалтын хөтөлбөрт тусгагдсан тавигдах шаардлагыг хангасан байхын хэрэгцээ сэдвийн талаар гүнзгий мэдлэгтэй, сургалтад оролцогчдын хэрэгцээ, шаардлагын талаар болон тэдний эрх зүйн соёл, ажлын орчин, зохион байгуулалтын талаар сайн ойлголттой байвал зохино. Түүнчлэн харилцааны болон шүүгч-насанд хүрэгчийг сургах арга зүйн чадварт суралцсан, мэдээллийн технологийн орчин үеийн, шинэлэг арга зүйг эзэмшсэн байна.

Сургагч багш харилцааны соёл, шүүгч-насанд хүрэгчийг сургах хийнгээ-суралцах, оролцоот сургалтын арга зүй, мэдээллийн технологийг сургалтад ашиглах чадвар зэргийг эзэмшүүлэх тухайлсан сургалтад хамрагдсан байвал зохино.

Сургалт оролцогчдод үр өгөөжтэй байх зарчмыг баримталж сургалтын сэдвийн онцлогоос хамаарч эрх зүйн салбарын эрдэмтэн судлаач, бусад салбарын өндөр мэргэжилтэнг сургагч багшаар оролцуулна.

2.4.Шүүгч-багш

Шүүгч-багш сургалтын хөтөлбөрт тусгагдсан тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна шүүгчдийн дунд нэр хүнд бүхий, хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн алдаа, дутагдал гаргаж байгаагүй шүүн таслах ажиллагааны арвин туршлагатай гадаад, дотоодын шүүгч байна.

Шүүгч-багш харилцааны соёл, шүүгч, насанд хүрэгчийг сургах арга зүйн чадварт суралцсан, мэдээллийн технологийн орчин үеийн, шинэлэг арга зүйг эзэмшсэн байна.

Сургалтад оролцогчдын эрхэлж буй ажлын онцлог, хэтийн төлөвийг ойлгодог байх, тэдэнд практик зөвлөгөө, үнэ цэнэтэй санал зөвлөмж өгөх чадвартай байх шаардлагыг хамгийн сайн хангах нь шүүгчид өөрсдөө тул сургалтыг шүүгч-багш хөтлөн явуулахыг нэн тэргүүнд дэмжиж нийт сургалтын 70-аас доошгүй хувь нь шүүгч-багш байхад анхаарна.

2.5.Сургалтын хөтөлбөр

Шүүгчийн болон шүүгч бэлтгэх сургалтыг хэрэгцээ, судалгаанд үндэслэсэн, хууль тогтоомж, холбогдох журамд заасны дагуу боловсруулж баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

Сургалтын хөтөлбөрийн агуулга:

1. Шүүгчийн эрх зүйн болон бусад салбарын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх замаар шүүн таслах ажиллагааны чанарыг сайжруулах, орчин үеийн нийгэмд шүүхийн ил тод, нээлттэй байдлыг улам дээшлүүлэхэд чиглэнэ.
2. Шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг чадварыг сэргээх, нэмэгдүүлэх, мэргэжил, ёс зүй, зан төлөвт чиглэнэ.

Шүүгч жилд хамрагдах сургалтын нийт багц цагийн хэмжээ дөрвөн багц цагаас багагүй байна. Үүнээс 3 багц цаг нь заавал судлах, 1 багц цаг нь сонгон судлах сургалт байна. Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад үүнээс илүү багц цаг хангахаар заасан тохиолдолд тухайн зохицуулалтыг баримтална. Сургалтын найман цагийг нэг багц цагт тооцох ба нэг цагийн сургалтын үргэлжлэх хугацаа 45 минут байна. Сургалтын хөтөлбөр нь багц цагийн хэмжээ, сэдэв, төрлийн хувьд шүүгчийн хамрагдвал зохих багц цагаас илүү хэмжээ, олон сэдэв, төрөлтэйгээр санал болгосон сонголт бүхий байна.

2.6.Сургалтын мэдээлэл

Сургалтын талаарх мэдээллийг хамрагдвал зохих оролцогчдод хангалттай хугацааны өмнө бүрэн хүргэнэ.

Сургалт болон багц цаг хангахтай холбоотой аливаа мэдээллийг шүүгч цахимаар авах боломжыг бүрдүүлнэ.

Ил тод, нээлттэй байдлыг хангаж сургалтын үйл ажиллагааны талаар олон нийтэд зохих журмын дагуу тогтмол мэдээлнэ.

2.7.Сургалтын зардал

Шүүхийн сургалтыг улсын төсөв буюу Улсын дээд шүүхийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд Монгол Улсын олон улсын гэрээ, гадаад улсын шүүх, олон улсын болон гадаад улсын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад гадаад улс болон олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр сургалтын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Сургалтын зардалд сургалтын хөтөлбөр боловсруулсны хөлс, сургалт зохион байгуулах танхимын түрээс, сургалтын хэрэглэгдэхүүн, сургагч багшийн хөлс, ном, гарын авлага боловсруулж хэвлүүлэх зардал, сургалтын зохион байгуулалтын зардал, сургалтад ирж, буцах замын зардал, албан томилолт, контент бэлтгэх зардал зэрэг хамаарна.

Сургалт зохион байгуулах төлөвлөгөө, төсвийг тухайн сургалтыг хариуцсан сургалтын менежер боловсруулах ба нэгжийн удирдлагад танилцуулан, Академийн захирлын тушаалаар батална.

Шүүгч бэлтгэх сургалтын зардлыг суралцагч өөрөө бүрэн хариуцна. Сургалтын зардлыг тооцооллыг үндэслэн сургалтын хөтөлбөрийн хорооны саналыг авч Академийн захирлын тушаалаар тогтооно.

Заавал судлах сургалтад хамрагдсан шүүгчид олгох албан томилолт болон замын зардлыг холбогдох журмын дагуу тооцон олгоно.¹

Хэрвээ сургагч багш сургалттай холбоотой нэмэлт зардал гаргасан тохиолдолд баримтыг үндэслэн нөхөн олгож болно. (Тухайлбал, томилолт болон замын зардал, бусад холбогдох зардал)

Сонгон судлах сургалтыг цахимаар зохион байгуулахыг эрмэлзэх бөгөөд танхимаар зохион байгуулсан сургалтад сайн дурын үндсэн хамрагдахад шүүгч өөрөө зардлаа хариуцахаар зохион байгуулж болно.

ГУРАВ.СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1.Сургалтын төрөлжилт

Шүүгчийн сургалт нь төрөлжилтийн хувьд онцлог, шалгуураас хамааран олон төрөлд ангилагдаж болох бөгөөд тэдгээр сургалтыг зорилго, хамрах хүрээгээр дараах байдлаар төрөлжүүлж, цогц байдлаар авч үзэн зохион байгуулна:

1. Эрх зүйн мэдлэг дээшлүүлэх сургалт

Энэ төрлийн сургалтаар шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хуулийг зөв хэрэглэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах эрх зүйн салбарын мэдлэгийг дээшлүүлнэ.

2. Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх сургалт

Энэ төрлийн сургалтаар шүүгч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай шүүх хуралдаан удирдах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, шүүхийн хэлэлцүүлэг зохион

¹ “Шүүгчид албан томилолт, замын зардал олгох журам”

байгуулах, олон тооны хавтаст болон хугацаа сунгасан хэрэгтэй ажиллах, хэргийн хөдөлгөөнийг удирдах, хэрэг хянан шийдвэрлэх хугацааны менежмент, шүүхийн шийдвэр боловсруулах, шүүх хуралдааны дэгийн зөрчил шийдэн зохицуулах, гэрчээс асуух, шүүх хуралдааны танхимын ялгаатай нөхцөл байдалд зохицох зэрэг хууль зүйн ур чадварыг хөгжүүлнэ.

3. Салбар дундын мэдлэг дээшлүүлэх сургалт

Энэ сургалтаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад нотлох баримтыг тал бүрээс, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлэхэд шаардлагатай санхүү, татвар, эдийн засгийн шинжилгээ, мэдээллийн технологи, цахимжилт, байгалийн шинжлэх ухаан, сэтгэл судлал зэрэг салбар дундын боловсрол, мэдээлэл, мэдлэгийг дээшлүүлнэ.

4. Нийгмийн мэдрэмжийг ахиулах сургалт

Энэ сургалтаар нийгмийн олон талт байдал, хөгжлийн хандлагыг мэдэрч зэрэгцэн хөгжих, субъектив хүчин зүйлээс ангид байх, шүүгч үзэл бодлоо илэрхийлэх, нийгмийн сүлжээнд харилцах, хүний эрхэм чанарыг хүндэтгэн хэргийн оролцогчдод үл ялгаварлан хандах, хэргийн оролцогчдын сэтгэл ханамжийг бүрдүүлэгч хүчин зүйлсийг тодорхойлох, бий болгох замаар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүлж ахиулна.

5. Хувь хүний хөгжил, ёс зүйн сургалт

Өөрийгөө таньж мэдэж, өөрийн мөн чанар, үнэ цэнийг бий болгох, өөртөө шинэ хандлага, эерэг зан чанаруудыг хэвшүүлэх, мөн стресс даван туулах, сэтгэл хөдлөлөө хянах, хэргийн оролцогчид, олны өмнө ярих, илтгэх зэрэг бусад төрлийн чадварыг хөгжүүлэх, хуульчийн болон шүүгчийн сахилга, ёс зүйн шаардлагыг хангах соёл, дадлыг төлөвшүүлж, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг эзэмшүүлнэ.

Хууль тогтоомж, эрх зүйн бусад актад заасан шүүгч заавал судлах сургалтын агуулгыг тодорхойлоход энд дурдсан сургалтын төрлүүдийг зохих хэмжээгээр харгалзаж цогц байдлаар авч үзнэ.

Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас Сургалтын нэгдсэн бодлогод заасан багц цагийг бүрэн хангаагүй шүүгчийг багц цаг хангах нөхөн сургалтад хамрагдах боломжоор хангана.

Шүүгчийг мэргэшүүлэх гадаад сургалтын хөтөлбөрийг шүүх, шүүгчийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсны үндсэнд гадаад талтай харилцан тохиролцон бэлтгэж, нээлттэй, ил тод, хүртээмжтэй, өрсөлдөөнт зарчимд тулгуурлан оролцогчийг сонгон гадаад сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамруулна.

Гадаад харилцааны хамтын ажиллагааны хүрээнд гадаад улсад зохион байгуулах туршлага солилцох айлчлал, гадаад улсын шүүхийн үйл ажиллагаатай танилцах, мэдээлэл солилцох уулзалт, арга хэмжээнд оролцох шүүгчдэд энэ шаардлага хамаарахгүй.

Шүүгч бэлтгэх сургалт нь шүүгч болох зорилготой хуульчийн хууль зүйн мэдлэг чадварыг сэргээх, нэмэгдүүлэх, мэргэжил, ёс зүй, зан төлөвт чиглэсэн агуулга бүхий онол, практик хосолсон сургалт байна.

Хууль зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт

Үндсэн хуулийн эрх зүй, шүүхийн эрх зүйн болон шүүгчийн тогтмол хэрэглэдэг эрх зүйн эх сурвалжийн үндсэн хэм хэмжээ, зарчмуудыг бататган мэдлэг сэргээх лекц, шийдвэр боловсруулах, хууль тайлбарлан хэрэглэх, шүүх хуралдаанд бэлтгэх, шүүх хуралдааныг удирдах, хэлэлцүүлэг хийх, нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шийдвэр гаргах, бичих, танилцуулах, гардуулах зэрэг шүүгчийн гүйцэтгэдэг чиг үүрэгтэй танилцаж, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх дадал олгоход чиглэнэ.

Мэргэшил, ёс зүй, зан төлөвийн сургалт

Шүүгчийн ёс зүй, харилцаа, хандлагыг төлөвшүүлэх, тодорхой асуудлыг тогтсон стандарт мэргэжлийн ёс зүй, үйл ажиллагааны дүрмийн хүрээнд шийдэх чадвар эзэмшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

Шүүгч бэлтгэх сургалтыг Академийн захирлын баталсан хөтөлбөрийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэмжлэгтэйгээр зохион байгуулна.

3.2.Сургалтын хэлбэр, арга зүй

Сургалтад шинэлэг, орчин үеийн дэвшилтэт хэлбэр, аргыг тогтмол нэвтрүүлж, бие даан, алсын зайнаас суралцах оролцоот сургалтын арга зүйг түгээмэл хэрэглэнэ.

Шүүгчийн сургалтыг сургалтын хэрэгцээ, шаардлага, төрөл, чиглэл, сэдвээс хамааран танхим, цахим, танхим ба цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулна. Ур чадвар хөгжүүлэх, зан байдал, хандлагад чиглэсэн сургалтыг цахим бус хэлбэрээр зохион байгуулах нь илүү үр өгөөжтэйг анхаарвал зохино. Сургалтын агуулгыг харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт, шийдлийг ашиглан цахим хэлбэрээр хүргэхдээ сургалтын чанар, үнэлгээнд тавигдах бүх шаардлагыг хангана.

Оролцоот сургалтын арга зүйн 70:20:10 зарчим буюу сургалтын 70 хувьд хийнгээ суралцах, 20 хувьд бусад оролцогчдоос суралцах, 10 хувьд алсын зайн болон видео хичээлээс суралцах сургалт, арга зүйг нэвтрүүлэх зорилгын хүрээнд хийнгээ суралцах арга зүйг жил бүр үе шаттай ахиулж, сургалтын чанарыг хангана.

Хийнгээ суралцахуй. Хийнгээ суралцах нь оролцогч өөрөө зорилгоо тодорхойлж, өөрийгээ чиглүүлэн суралцаж буй явдал бөгөөд ажлын байран дахь хийнгээ суралцахуй нь оролцогчийн ур чадвар, мөн сургалтыг дэмжсэн орчноос хамаарна. Хийнгээ суралцах сургалт нь ажлын байранд суралцах, жишээ тохиолдол дээр ажиллах, асуудал шийдвэрлэх, сорилттой даалгавар шийдэх, бусад оролцогчидтой тодорхой сэдвээр хамтран ажиллах, шинэ даалгавар шийдэх, бусад шүүгчийн шүүхийн хэлэлцүүлэг, эцэслэгдсэн шийдвэрт дүн шинжилгээ хийх, тогтмол санал солилцох, жишээ тохиолдол, асуудал шийдвэрлэх зэргээр явагдана. Хийнгээ суралцах арга зүйн үр өгөөжийг иж бүрэн бий болгох үндэс нь сургалтад оролцогчид онол болон практикийн мэдлэгийн суурь сайтай байхад оршино. Энэ сургалт нь тухайн шүүхийн бусад шүүгчид, удирдлагын дэмжлэг, мөн сургалт зохион байгуулагчийн сайн төлөвлөлт, чиглүүлэг, гүйцэтгэлийн хяналт, урьдчилан баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу хэрэгжинэ.

Бусад оролцогчдоос суралцахуй. Энэ сургалт нь хамтран ажиллагсадтай туршлагаа хуваалцах, ментор хийх, бүлгээр харилцан туршлагаа хуваалцах (*intervision*), чиглүүлэх, албан бус яриа хэлэлцүүлэг, солилцооны хөтөлбөр, танилцах айлчлал, бусдад заах байдлаар хэрэгжинэ. Бусад оролцогчдоос суралцах сургалтыг сайн бэлтгэл, зохион байгуулалтын үндсэнд хийх бөгөөд туршлагатай шүүгч-сургагч багш ментор хийх, чиглүүлэх зэргээр зохион байгуулна. Энэ суралцахуйн явцад сургалт зохион байгуулагч агуулгад шууд хяналт тавих шаардлагагүй бөгөөд оролцогч сургалтын агуулгыг өөрийн хэрэгцээнд үндэслэн тодорхойлж, мэргэжлийн хөгжлөө өөрөө хөтөлнө.

Лекц, контентоос суралцахуй. Лекц, контентоос суралцахуй нь семинар, сургалт, хичээлийн материал уншиж судлах, цахим сургалтын (*e-learning*) хэрэгсэл ашиглах зэрэг сургалтын сонгодог хэрэгслийн тусламжтай явагдах сургалт бөгөөд сургалтын агуулга практикт чиглэсэн байна. Сургалтаар олгох онолын мэдлэг нь тухайн онолыг практикт хэрэглэх зааварчилгаа, жишээ зэргийг агуулсан байвал зохино.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

Сургалт зохион байгуулагч сургалтын ажиллагааг цогцоор үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ. Үнэлгээ нь сургалтад оролцогч бүрийг хамруулах, хараат бус үнэлэх зарчимд тулгуурлах бөгөөд үнэлгээний үр дүнд үндэслэн шүүгч, шүүгч бэлтгэх сургалтын үйл ажиллагааг сайжруулах, улам боловсронгуй болгоход чиглэгдэнэ. Сургалтын үнэлгээний шилдэг арга, хэлбэр, сайн туршлагыг харгалзан сургалтад оролцогчийн сэтгэл ханамж, суралцахуйн чанар, сургагч багшийн ажил, сургалтын зохион байгуулалтыг бодитой үнэлнэ.

4.1.Сургалтын хөтөлбөрийг үнэлэх

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох журам²-д заасны дагуу үнэлнэ.

4.1.Оролцогчийн суралцахуйг үнэлэх

Сургалтад хамрагдсан оролцогч мэдлэг, ур чадвараа хөгжүүлж, дээшлүүлсэн байдлыг сургагч багшийн урьдчилан бэлтгэсэн асуулга, сорилго, бусад даалгавар, чиглүүлэгч багшийн тайлангаар үнэлэх бөгөөд оролцогч үнэлгээний 50 хувьд хангалттай үнэлгээ авсан тохиолдолд тухайн сургалтын багц цагийг тооцно. Оролцогчийн үнэлгээ тухайн сургалтын багц цаг хангахад хүрээгүй тохиолдолд үнэлгээнд дахин хамрагдах нь нээлттэй байна.

4.2.Сургалтын ажиллагааг үнэлэх

Оролцогч хамрагдсан сургалтын үйл ажиллагаанд асуулгаар үнэлгээ өгнө. Үнэлгээний асуулгад сургагч багшийн сургалтын ажиллагаа болон сургалтын зохион байгуулалтын талаарх үнэлгээ, оролцогчийн сэтгэл ханамжийг тодруулах асуултыг тусгана. Энэ арга хэмжээг хэрэгжүүлж, үнэлгээний тайланг цаашдын сургалтын ажиллагааг сайжруулахад харгалзаж, эргэлтэд оруулна.

Үнэлгээний асуулга нь үр дүнг хялбар харьцуулах боломж бүрдүүлж олон сургалтын үйл ажиллагаанд ижил үнэлгээний аргыг ашиглавал зохино. Оролцогч санал шүүмжлэлтэй тохиолдолд тухайн хариултыг илэрхийлэх боломжтой олон сонголтот хэлбэрээр үнэлгээний асуулга, асуултыг боловсруулна.

ТАВ.НЭГДСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Сургалтын хөтөлбөрийн хороо энэхүү “Сургалтын нэгдсэн бодлого”-д заасан зорилтын хэрэгжилтийг доор дурдсан шалгуур үзүүлэлтээр 2027 онд үнэлж дүгнэнэ. Хэрэгжилтийн үнэлгээг Сургалтын хөтөлбөрийн хорооноос чиглэл болгосны дагуу Шүүхийн академи, эсхүл хөндлөнгийн мэргэжилтнүүдийн баг хийнэ.

Зорилт 1.Сургалтын үйл ажиллагаа, агуулга шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг ямагт сахих, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад чиглэнэ.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт: Сургалтын хөтөлбөр бүрийн агуулга, хамарсан сэдэв, судлахаар сонгосон шүүхийн шийдвэр, жишээ тохиолдол нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулахааргүй, хөндөөгүй байна. Сургалтыг дээд шатны шүүгч-сургагч багш хөтлөн явуулахад оролцогч-шүүгчийн дотоод итгэлийн хараат бус байдлыг хөндөхгүй. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг Улсын дээд шүүхээс гаргасан хуулийн тайлбар, хэрэг маргааныг хяналтын шатны журмаар эцэслэн шийдвэрлэсэн тогтоолд үндэслэн сургалтад дурдан ханган ажилласан байна.

² Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Сургалтын хөтөлбөрийн хорооны журмын 5 зүйл

Зорилт 2. Сургалтын хэрэгцээ, шаардлагыг шүүх, шүүгч болон шүүхээр үйлчлүүлэгчдээс тандан судлах тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлнэ.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт: Сургалтын хэрэгцээ, шаардлага, зорилгыг шүүгч, шүүх, шүүхээр үйлчлүүлэгчдээс тандан судлах цахим тогтолцоо бүрдсэн байна. Шаардлагатай сургалтын чиглэл, сэдвийг тодорхойлоход холбогдох судалгаа, шүүхийн практикийн тайлан гаргасан байна.

Зорилт 3. Сургалт эрх зүйн болон бусад салбарын мэдлэгийг хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн олон талт байдлыг мэдрэх хандлага чадварыг ахиулахад чиглэнэ.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт: Эрх зүйн мэдлэг дээшлүүлэх, ур чадвар хөгжүүлэх, салбар дундын мэдлэг дээшлүүлэх, нийгмийн мэдрэмжийг ахиулах сургалтуудыг цогц байдлаар авч үзсэн сургалтын хөтөлбөрүүд батлагдан сургалтын нэгдсэн бодлого хэрэгжсэн байна.

Зорилт 4. Сургалтад шинэлэг, орчин үеийн дэвшилтэт хэлбэр, аргыг нэвтрүүлж, зайн сургалтыг нийт зохион байгуулаж буй сургалтын 70 хувьд хүргэж, оролцоот сургалтын хэлбэр, арга зүйг түгээмэл хэрэглэнэ. Оролцоот сургалтын арга зүйн 70:20:10 зарчим буюу сургалтын 70 хувьд хийнгээ-суралцах, 20 хувьд бусад оролцогчдоос суралцах, 10 хувьд лекц, контентоос суралцах арга зүйг нэвтрүүлэх зорилгын хүрээнд хийнгээ суралцах сургалтын эзлэх хувийг үе шаттай ахиулж сургалтын чанарыг хангана.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт: Сургалтад шинэлэг, орчин үеийн дэвшилтэт хэлбэр, аргыг нэвтрүүлсэн байна. Оролцоот сургалтын арга зүйн 70:20:10 зарчмыг үе шаттай нэвтрүүлсэн байна. Хийнгээ-суралцах сургалтын эзлэх хувийг эхний жилд нийт сургалтын 10 хувьд, хоёр дахь жилд 20 хувьд, гурав дахь жилд 30 хувьд хүргэж ахиулсан байна.

Зорилт 5. Сургалтын ажиллагааг цогцоор үнэлнэ. Сургалтын үнэлгээний шилдэг арга, хэлбэр, сайн туршлагыг харгалзан сургалтад оролцогчийн суралцахуй, сургагч багшийн ажил, сургалтын зохион байгуулалтыг бодитой үнэлэх арга хэмжээг хэрэгжүүлж, үнэлгээний тайланг цаашдын сургалтын ажиллагааг сайжруулахад харгалзаж, эргэлтэд оруулна.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт: Сургалт зохион байгуулагч сургалтын ажиллагааг цогцоор үнэлэх цахим болон бусад хэлбэрийн тогтолцоог бүрдүүлсэн байна. Сургалтын үнэлгээний шилдэг арга, хэлбэр, сайн туршлага нэвтэрсэн байна. Сургалтын үнэлгээг сургалтын чанар, зохион байгуулалтыг сайжруулахад эргэлтэд оруулсан байна.